2026 | “ЛэндМН ББСБ” ХК III улирлын санхүү, үйл ажиллагааны тайлан

Агуулга

“ЛэндМН ББСБ” ХК-ийн 2026 оны III улирлын
санхүү, үйл ажиллагааны тайлан

Үйл ажиллагааны хураангуй 01

Санхүүгийн тайлан 02

Компанийн засаглал 03

МОНГОЛ УЛСАД АНХ УДАА: КОМПАНИД ЗОРИУЛСАН ЗЭЭЛИЙГ ЦАХИМЖУУЛЛАА.

“ЛэндМН ББСБ” ХК (цаашид “ЛэндМН”) нь технологийн дэвшлээр дамжуулан санхүүгийн үйлчилгээг илүү хурдан, хялбар, хүртээмжтэй болгох эрхэм зорилгынхоо хүрээнд Монгол Улсад анх удаа “FLEXI BUSINESS-КОМПАНИД ЗОРИУЛСАН ДИЖИТАЛ ЗЭЭЛ” бүтээгдэхүүнийг 2026 оны 05 дугаар сард зах зээлд албан ёсоор танилцуулж, Монголын санхүүгийн салбарт бас нэгэн шинэ хуудсыг нээлээ.


Бүтээгдэхүүний онцлог ба давуу тал:


- **100% Цахим шийдэл:** Уламжлалт зээлийн нүсэр шат дамжлагыг бүрэн халж, зөвхөн компанийн орлого хүлээн авдаг дансны хуулганд үндэслэн зээлийн эрхийг цахимаар, хоромхон зуурт тооцоолно.
- **Барьцаа хөрөнгө шаардахгүй:** Бизнес эрхлэгчдэд хамгийн их тулгардаг барьцаа хөрөнгийн шаардлагаас бүрэн чөлөөлсөн.
- **Уян хатан санхүүжилт:** Аж ахуйн нэгжүүд 100 сая хүртэлх төгрөгийн зээлийн шугамыг ямар нэгэн хүндрэлгүйгээр, шуурхай шийдвэрлүүлэн авах боломжтой.

Энэхүү бизнесийн бүтээгдэхүүн нь банк, санхүүгийн байгууллагын өндөр шалгууруудыг хангахад хүндрэлтэй байдаг олон компаниудад эргэлтийн хөрөнгөө шуурхай шийдвэрлэж, үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах боломжийг нээж өгч байна.

Бодит үр дүн ба Экосистем:

ЛэндМН нь улс орны эдийн засгийн гол хөдөлгүүр болсон бичил, жижиг дунд бизнес эрхлэгчид, аж ахуйн нэгжүүдийнхээ өсөлтийг дэмжих, борлуулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр тасралтгүй анхааран ажилладаг. Бизнес эрхлэгчид, харилцагчид болон санхүүгийн байгууллагуудыг нэгтгэсэн хүчирхэг экосистемийг цогцлоох энэхүү зорилтын үр дүнд “Flexi Business-Компанид зориулсан дижитал зээл” зах зээлд нэвтэрсэн даруйдаа мянга гаруй зээлийн хүсэлт хүлээн авч, өдгөө зуу зуун компанийн санхүүгийн хэрэгцээг цаг алдалгүй, шуурхай ханган ажиллаж байна.





LENTO: ТАНЫ БИЗНЕСИЙН УХААЛАГ ШИНЖЭЭЧ

Бизнес эрхлэгч та “Орлого орж байгаа мөртлөө яг хэдэн төгрөгийн ашигтай ажиллаж, хаашаа хичнээн зардал гарснаа нарийн мэдэхгүй байна уу?”, “Санхүүгийн нүсэр тайлангуудыг хараад ойлгоход хэцүү байна уу?”

Хэрэв тийм бол энэ бүх асуудлыг ЛэндМН-ээс 2026 оны III улиралд бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдэдээ зориулан танилцуулж буй **Lento** платформ ердөө хэдхэн минутын дотор, хамгийн энгийнээр шийдэх болно. Бид зөвхөн санхүүжилт олгогч бус, таны бизнесийн өсөлтийг дэмжих **урт хугацааны найдвартай түнш** байх зорилгоор энэхүү ухаалаг шийдлийг бизнес эрхлэгч танд зориулан бүтээлээ.


Яагаад Lento-г ашиглаж эхлэх хэрэгтэй вэ?

- **Ганцхан үйлдлээр:** Та ердөө компанийн харилцах дансны хуулгаа оруулахад л **Lento** таны бизнесийн үйл ажиллагаанд хэрэгтэй бүх мэдээллийг хэдхэн минутын дотор боловсруулна.
- **Хиймэл оюуны гайхалтай хурд ба нарийвчлал:** Олон жилийн дата өгөгдөл дээр үндэслэн хөгжүүлсэн хиймэл оюун ухаант модель нь таны санхүүг нарийвчлан шинжилнэ.
- **Хүн бүрд ойлгомжтой энгийн байдал:** Санхүүгийн нарийн төвөгтэй, хэцүү нэр томьёог мартаж болно. Танай компанийн ашиг, алдагдал, мөнгөн урсгал хаашаа чиглэж байгааг хэн ч харсан шууд ойлгохуйц маш энгийн хэлбэрээр нэгтгэн харуулна.
- **Үнэ төлбөргүй:** Та ямар нэгэн үнэтэй, ашиглахад хэцүү программ хангамж худалдаж авах шаардлагагүй. **Lento** танд бизнесийн үйл ажиллагаанд шаардлагатай бүх мэдээллийг 100% үнэ төлбөргүйгээр боловсруулан харуулна.
- **Бизнесийн ухаалаг удирдлага:** Энэхүү платформын тусламжтайгаар та өөрийн бизнест бодит үнэлэлт дүгнэлт хийж, зардлаа оновчтой удирдан, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж, бизнесийн өсөлтөд чиглэсэн хамгийн зөв шийдвэрүүдийг цаг алдалгүй гаргах боломжтой.

Бизнесээ амжилттай удирдаж, өргөжүүлэн тэлэхийн үндэс нь “Ойлгомжтой санхүү” байдаг. Та яг одоо **Lento** платформд нэгдэж, **санхүүгийн асуудлаа технологийн шийдэлд даатгаад, зөвхөн бизнесээ хэрхэн өргөжүүлэх дээр анхаарлаа төвлөрүүлээрэй.**

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Санхүүгийн голлох үзүүлэлтүүд /Өссөн дүнгээр/:



Орлого, үр дүнгийн нэгтгэсэн тайлан /өссөн дүнгээр/

/тэрбум төгрөг/	2026.I	2026.II	2026.III
Нийт хүүгийн орлого	39.3	79.9	123.2
Хүүгийн зардал	(12.4)	(26.9)	(41.4)
Цэвэр орлого	**26.9**	**53.0**	**81.8**
Зээлийн үйл ажиллагаатай холбоотой зардал	(11.0)	(23.0)	(35.1)
Үйл ажиллагааны цэвэр орлого	**15.9**	**30.0**	**46.7**
Удирдлагын болон үйл ажиллагааны зардал	(3.7)	(7.0)	(10.3)
Татварын өмнөх ашиг	**12.2**	**23.0**	**36.4**
Татварын зардал	(2.3)	(4.9)	(8.5)
Цэвэр ашиг	**9.9**	**18.1**	**27.9**

Санхүү байдлын нэгтгэсэн тайлан

Хөрөнгө /тэрбум төгрөг/	2026.I	2026.II	2026.III
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	64.0	59.8	22.7
Зээлийн багц (цэвэр)	313.4	294.3	329.6
Бусад хөрөнгө	15.3	19.6	36.4
Үндсэн хөрөнгө	4.1	4.1	3.9
Биет бус хөрөнгө	1.3	1.7	1.6
Нийт хөрөнгө	**398.1**	**379.5**	**394.2**

Өр төлбөр болон эздийн өмч			
Өр төлбөр	**286.3**	**271.6**	**276.6**
Эх үүсвэр	254.1	225.7	233.4
Хоёрдогч өглөг	13.6	24.4	21.5
Бусад өглөг	18.6	21.5	21.7
Эздийн өмчийн дүн	**111.8**	**107.9**	**117.6**
Хувьцаат капитал	8.5	8.5	8.5
Хуримтлагдсан ашиг	103.3	99.4	109.1
Нийт өр төлбөр болон эздийн өмч	**398.1**	**379.5**	**394.2**

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа

Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”) нь 2026 оны III улиралд 1 удаа ээлжит хурал, 3 удаа эчнээ санал хураалт явуулан нийт 7 тогтоол гаргав. Эдгээр шийдвэрээр Нэгж эрх эргүүлэн худалдан авах, Компанийн Дотоод аудитын дүрмийг шинэчлэн батлах, Зээлээр эх үүсвэр татан төвлөрүүлэхтэй холбоотой асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэсэн байна.

ЛэндМН нь ТУЗ-ийн тогтоолуудыг холбогдох журамд заасны дагуу “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд тухай бүр мэдээлсэн болно.

д/д	Шийдвэр гаргасан огноо	Ирц	Шийдвэр гаргасан хэлбэр	Батлагдсан тогтоолын тоо
1	2026 оны 08 дугаар сарын 07	100%	Эчнээ санал хураалт	2
2	2026 оны 08 дугаар сарын 17	100%	Ээлжит хурал	2
3	2026 оны 09 дүгээр сарын 09	100%	Эчнээ санал хураалт	1
4	2026 оны 09 дүгээр сарын 29	100%	Эчнээ санал хураалт	2

Удирдлага зохион байгуулалт	Санхүү	Эрх олгох	Үйл ажиллагаа	Бизнес стратеги
-	4	2	1	-

2026 оны III улиралд Компанийн зүгээс (i) зээлийн бодлогын тогтолцоог үнэлж, боловсронгуй болгох, (ii) харилцагчийн сегментчлэлийн тогтолцоо боловсруулах, (iii) зээл судлан шийдвэрлэх үйл явцыг шинэчлэх, (iv) кредит скорингийн загварын стратегийг шинэчлэх, хөгжүүлэх ажлын хүрээнд 1 сонирхлын зөрчилтэй хэлцэлд ЛэндМН-ийн ТУЗ-өөс Монгол Улсын Компанийн тухай хуульд заасан журмын дагуу зөвшөөрөл олгогдсон байна.

